



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Ойдов
Утас: 261885
Цахим хаяг: oidovts@audit.gov.mn

Аудитор: Ж.Болормаа
Утас: 260512
Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2016 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2016/1/САГ-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, шударга бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 26-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 25-наас 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын аудитор Ж.Болормаа гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Зохицуулах зөвлөлийн удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Зохицуулах зөвлөл нь дараах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Үүнд,

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах тухай хууль

- Усны тухай
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Нийгмийн даатгалын тухай
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 46 дугаар тогтоол
- Засгийн газрын 2012 оны 183 дугаар тогтоолууд зэрэг байна.

Тайлант хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй гол хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Зөвлөлийн үйл ажиллагаа нь “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”, Засгийн газрын 2012 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм”-ээр зохицуулагдах бөгөөд тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй хэрэглэгчийн төлөөлөл, салбарын мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий бие даасан, хараат бус хамтын удирдлагын байгууллага юм.

Зохицуулах зөвлөлийн эрхэм зорилго нь Монгол улсад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн чанар, стандарт бүхий найдвартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг баталгаажуулах оновчтой зохицуулалтыг хийхэд оршино.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Зохицуулах зөвлөлийн захирал Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тус зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн

захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдаас түүвэрлэн аудитын нарийвчилсан горим, сорил 28-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажилласан байна.

Зохицуулах зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “ACOLOUS” програмаар боловсруулж байна.

Зохицуулах зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзсэн байна. /ТАБ-СТА-В-2/

Зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлоын 1% буюу 4.9 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Зохицуулах зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналт сул байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Засгийн газрын 2015 оны 75 дугаар тогтоолоор Зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны төсөв батлагдсан бөгөөд Ус хангамж, ариутгах татуургын зохицуулалтын үйлчилгээний хөлсний орлогыг 490.8 сая төгрөгөөр тогтоосон байна.

Засгийн газрын тогтоолын дагуу Зохицуулах зөвлөлийн 2015 оны 16 дугаар тогтоолоор 2015 онд Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөх зохицуулалтын үйлчилгээний хураамжийн хэмжээг баталсан байна.

Зохицуулах зөвлөл нь 2015 онд 482.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж батлагдсан орлогын төлөвлөгөөг 98.3%-р биелүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 467.4 сая төгрөгөөр тайлагнагдаж зардлын гүйцэтгэл 95.2%-тай байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас төлсөн зохицуулах үйлчилгээний орлогыг ХХБ-ны 460006270 дугаар харилцах дансаар дамжуулан төвлөрүүлж үйл ажиллагаандаа зарцуулдаг байна.

Зохицуулах зөвлөлийн 2015 оны батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулахад тээвэр шатахууны зардал 1.8 сая төгрөгөөр буюу 44%-р хэтэрсэн байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Зохицуулах зөвлөл нь Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны “Журам батлах тухай” 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн wsrg.gov.mn веб сайтад Шилэн данс цэсийг байршуулж дараах мэдээллийг оруулсан байна. Үүнд,

- Зохицуулах зөвлөлийн 2015 оны 16 дугаар тогтоол буюу Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөх зохицуулалтын үйлчилгээний хураамжийн хэмжээ
- Байгууллагын 2015 оны цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 552.2 сая төгрөгийн 38 гүйлгээ,
- Байгууллагын 1,2,3-р улирлын санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг байршуулсан байна.

Байгууллагын веб сайтын Шилэн данс цэсэнд төсөв/гүйцэтгэл, тендер, худалдан авалт зэрэг дэд цэсэнд тавигдах мэдээлэл байгаа боловч оруулаагүй байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт болон хяналтын 36 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлүүдийг олж тогтоов.

- 2015 оны санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл 6.4 сая төгрөгөөр, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан 25.4 сая төгрөгөөр, нийт цэвэр мөнгөн гүйлгээ 40.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.
- Тайлант жилд байгууллагын няравын програмын 2 эрх 550.0 мянган төгрөгөөр худалдан авсан боловч зориулалтын дагуу ашиглахгүй байгаагаас санхүүгийн тайланд хөрөнгийн бүртгэл 3.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.
- Дээрх алдаанууд нь санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй “ACOLOUS” програмын шинэчлэл, хөгжүүлэлтийг тухай бүр хийлгэж, алдааг засаж залруулаагүй улмаас гарсан бөгөөд холбогдох ажилтнууд санхүүгийн програмыг бүрэн эзэмшиж ашиглах шаардлагатай байна.

Ес. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа үйлчилгээний орлого, зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант жилд гарсан онцлог гүйлгээг дурдвал:

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг дэлгэрэнгүй бүртгэх, албан тушаал, инженер техникийн ажилчид, ажлын байр, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээ, хэрэгцээ шаардлагыг бүрэн тусгаж зохицуулалт, төлөвлөлт хийх боломжийг бүрдүүлэх зорилготой тусгай зөвшөөрлийн онлайн бүртгэлийн програм хангамж боловсруулан туршиж байна.

Мэдээллийн сан боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан "Инно солюшн" ХХК-тай 2015 оны 3-р сарын 12-ны өдөр Мэдээллийн сан боловсруулах зөвлөх үйлчилгээний WSRC/2014/-MS02 тоот гэрээг 23.4 сая төгрөгөөр байгуулсан бөгөөд урьдчилгаа 14.1 сая төгрөгийг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил болон удирдлагын анхаарал хандуулах гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлангийн Кассанд байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл 24.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Жижиг мөнгөн сангийн картын дансны үлдэгдлийг мөнгөн хөрөнгөнд нэмж бүртгэж залруулга хийв.

2. Зохицуулах зөвлөлийн даргын 2015 оны А/54 дугаар тушаалаар байгуулагдсан Тооллогын комиссийн тайлангаар нийт 153.7 сая төгрөгийн хөрөнгө тоологдсон бол санхүүгийн тайланд Бараа материал 1.1 сая, Тоног төхөөрөмж 1.9 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материал, үндсэн хөрөнгийн тайланд 3.0 сая төгрөгийн залруулга хийв.

3. Санхүүгийн програмын ажиллагааны доголдлоос шалтгаалан сүүлийн хагас жилд зарим хөрөнгийн элэгдэл бодогдоогүй улмаас нийт 5.9 сая төгрөгийн элэгдлийн зардал үр дүнгийн тайланд тусгагдаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн програмын тохиргоо хийж 5.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг нөхөн тооцож үр дүнгийн тайланд тусгав.

4. Ажиллагсадтай холбоотой өглөгт бүртгэгдсэн 9.3 сая төгрөгийн цалингийн өглөгийг он гараад олгосон боловч 9.3 сая төгрөгийн тооцоог хаагаагүй он дамжин өглөгөөр бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаар бүртгэгдсэн 9.3 сая төгрөгийг залруулга хийж тайлант үеийн үр дүнд хаасан байна.

5. Засгийн газрын 2015 оны 75 дугаар тогтоолоор Зохицуулах зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны төсвийг 490.8 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн нийт зарлагад Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал 19.2 сая төгрөгийг оруулсан байгаа нь Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалыг зөрчсөн байна. /2014 онд төсвийн санал явуулсан байна./

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2015 оны Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай 7 дугаар тушаалын дагуу төсвийн төлөвлөлт хийж гүйцэтгэлийг хянах

Арван нэг. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайланд залруулагдаагүй алдаа гараагүй байна.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 101.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 99.8 сая төгрөгийн алдааг залруулав.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2014 оны санхүүгийн тайланд Өлзийт экаунт аудит ХХК аудит хийж 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг биелүүлж ажилласан байна.

Арван зургаа. Зөвлөмж

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгч менежментийн захидлыг хавсаргав.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлэгдсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

САГ-ЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ОЙДОВ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



Ж.БОЛОРМАА



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН

ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

АСУУДАЛ 1

*Санхүүгийн програм хангамжийн
ашиглалт*

АСУУДАЛ 2

Төсвийн төлөвлөлт ба зарцуулалт

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгасан болно.

Төрийн аудитын байгууллагын энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АСУУДАЛ 1: Санхүүгийн програм ханамжийн ашиглалт

Ажиглалт

Зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл 6.4 сая төгрөгөөр, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан 25.4 сая төгрөгөөр, нийт цэвэр мөнгөн гүйлгээ 40.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

Мөн тайлант жилд байгууллагын няравын програмын 2 эрх худалдан авсан боловч зориулалтын дагуу ашиглахгүй байгаагаас санхүүгийн тайланд хөрөнгийн бүртгэл 3.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

Дээрх алдаанууд нь санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй “ACOLOUS” програмын шинэчлэл, хөгжүүлэлтийг тухай бүр хийлгэж, алдааг засаж залруулаагүй улмаас гарсан бөгөөд холбогдох ажилтнууд санхүүгийн програмыг бүрэн эзэмшиж ашиглах шаардлагатай байна.

.

Эрсдэл

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, хэрэглэгчдэд бодитой бус мэдээлэл хүрэх

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.9. аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах гэсэн үүргийг биелүүлж ажиллах

Аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АСУУДАЛ 2: Төсвийн төлөвлөлт ба зарцуулалт

Ажиглалт

Засгийн газрын 2015 оны 75 дугаар тогтоолоор Зохицуулах зөвлөлийн Үйл ажиллагааны төсвийг 490.8 сая төгрөгөөр баталсан байна Төсвийн нийт зарлагад Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал 19.2 сая төгрөгийг оруулсан байгаа нь Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Зохицуулах зөвлөл нь 2015 онд 482.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж батлагдсан орлогын төлөвлөгөөг 98.3%-р биелүүлсэн бөгөөд батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулахад тээвэр шатахууны зардал 1.8 сая төгрөгөөр буюу 44%-р хэтэрсэн байна.

Эрсдэл

Холбогдох хуулийн заалт хэрэгжихгүй байх

Зөвлөмж

Сангийн сайдын 2015 оны Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай 7 дугаар тушаалын дагуу төсвийн төлөвлөлт хийж гүйцэтгэлийг хянах

Төсвийн тухай хуулийн 16.5.5. д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалтыг баримтлан ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2016.02.05 № 3/140
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Ч.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	97,751,278.10	124,750,076.76
2	Кассанд байгаа бэлэн мөнгө	976,846.00	255,777.00
3	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	96,774,432.10	124,494,299.76
7	АВЛАГА	6,454,748.83	54,495,826.64
8	Үндсэн үйл ажиллагааны авлага	-	54,495,826.64
9	Бусад авлага	6,454,748.83	-
10	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	415,354.93	-
12	Урьдчилж гарсан зардал	415,354.93	-
13	БАРАА МАТЕРИАЛ	4,394,588.00	892,555.40
14	Түүхий эд материал	781,000.00	319,000.00
17	Хангамжийн материал	3,612,588.00	573,555.40
19	Бусад	1,000.00	-
21	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,015,969.86	180,138,458.80
22	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	115,702,015.44	101,677,062.19
24	Биет хөрөнгө	115,210,557.18	96,455,048.47
27	Авто тээврийн хэрэгсэл	75,400,000.00	75,400,000.00
28	Хуримтлагдсан элэгдэл	(8,602,499.96)	(16,142,499.92)
29	Машин, тоног төхөөрөмж	36,597,359.00	39,294,359.00
30	Хуримтлагдсан элэгдэл	(18,653,263.55)	(28,154,522.02)
31	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,698,100.00	36,698,100.00
32	Хуримтлагдсан элэгдэл	(7,100,051.58)	(11,478,701.82)
38	Номын фонд	52,540.00	52,540.00
39	Бусад үндсэн хөрөнгө	869,990.00	869,990.00
40	Хуримтлагдсан элэгдэл	(51,616.73)	(84,216.77)
42	Биет бус хөрөнгө	491,458.26	5,222,013.72
43	Програм хангамж	830,000.00	5,880,000.00
44	Хасагдуулга	(338,541.74)	(657,986.28)
48	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	115,702,015.44	101,677,062.19
49	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	224,717,985.30	281,815,520.99
50	Богино хугацаат өр төлбөр	9,373,207.68	10,510,897.60
51	Өглөг	9,373,207.68	10,510,897.60
52	Ажиллагчидтай холбогдсон өглөг	9,373,207.68	(0.00)
57	Бусад өглөг	-	10,510,897.60

61	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	9,373,207.68	10,510,897.60
64	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	9,373,207.68	10,510,897.60
66	Өмнөх үеийн үр дүн	215,344,777.62	215,344,777.62
67	Тайлант үеийн үр дүн	-	55,959,845.77
69	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	215,344,777.62	271,304,623.39
70	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	224,717,985.30	281,815,520.99

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	-
18	Бараа, үйлчилгээний орлого	481,931,309.93	548,964,077.49
19	Өмчийн орлого	231,551.70	2,828,630.93
20	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	24,843.00	283,859.89
21	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	481,699,758.23	546,135,446.56
22	Үндсэн үйл ажиллагааны орлого	474,036,685.50	537,146,689.67
23	Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	7,638,229.73	8,704,897.00
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	481,931,309.93	548,964,077.49
27	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,961,516.64	482,759,024.12
28	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	289,312,328.41	305,524,179.57
29	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	261,391,810.27	275,880,388.39
30	Цалин	253,841,810.27	231,191,089.93
31	Нэмэгдэл цалин	-	7,632,053.50
32	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,344,600.75
33	Урамшуулал	7,550,000.00	16,712,644.21
35	Нийгмийн хамгааллын шимтгэл	27,920,518.14	29,643,791.18
36	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	22,846,060.29	24,418,001.18
37	Тэтгэврийн даатгалын шимтгэл	17,771,602.46	18,837,913.18
38	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,029,783.11	2,247,782.00
39	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,537,228.93	2,809,727.00
40	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	507,445.79	522,579.00
41	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,074,457.85	5,225,790.00
42	Тогтмол зардал	41,098,574.00	51,387,490.00
46	Байрны түрээс	41,098,574.00	51,387,490.00
47	Хангамж, бараа материалын зардал	20,269,140.51	22,353,509.09
48	Бичиг хэргийн материал	5,271,685.00	6,599,359.00
49	Тээвэр, шатахууны зардал	9,015,600.00	5,346,900.00
50	Шуудан холбоо интернетийн төлбөр	5,302,555.51	8,987,957.09
53	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	679,300.00	1,419,293.00

59	Эд хогшил, урсгал засварын зардал	1,042,900.00	7,342,415.00
60	Багаж хэрэгсэл	41,300.00	2,784,788.00
61	Тавилга	50,000.00	90,000.00
62	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	992,228.00	-
63	Урсгал засвар	951,600.00	4,467,627.00
64	Томилолт, зочны зардал	20,921,544.00	23,119,402.00
65	Гадаад томилолтын зардал	13,225,444.00	17,688,312.00
66	Дотоод томилолтын зардал	7,696,100.00	5,431,090.00
67	Гадаадын зочны зардал	-	2,575,763.51
68	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	27,114,413.31	36,755,094.70
69	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,104,700.00	1,960,350.00
70	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,039,588.00	587,400.00
71	Даатгалын үйлчилгээний төлбөр	2,231,000.00	1,791,825.30
72	Тээврийн хэрэгслийн татвар	1,100,000.00	220,500.00
73	Тээврийн хэрэгслийн оношилгоо	686,143.00	104,500.00
74	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	15,100,532.00	30,964,800.00
76	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	147,212.31	324,719.40
77	Улсын мэдээллийн маягтын зардал	1,705,238.00	801,000.00
78	Бараа үйлчилгээний бусад зардал	34,202,616.41	36,276,933.76
79	Бусад зардал	119,854.39	-
80	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	4,172,963.61	4,125,227.00
81	Сургалт семинар	9,871,306.00	7,803,990.00
82	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,038,492.41	21,771,953.25
88	ТАТААС	901,400.00	3,895,000.00
89	Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдэд	901,400.00	3,895,000.00
90	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	901,400.00	3,895,000.00
94	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,035,238.00	6,350,207.60
94	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	2,577,257.60
96	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	2,577,257.60
97	Бусад урсгал шилжүүлэг	2,035,238.00	3,772,950.00
100	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,705,238.00	2,972,950.00
105	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	330,000.00	800,000.00
120	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	436,898,154.64	493,004,231.72
121	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	45,033,155.29	55,959,845.77
122	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
126	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
131	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	45,033,155.29	55,959,845.77

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
3	2014 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл			170,311,622.33	170,311,622.33
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			170,311,622.33	170,311,622.33
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
7	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
8	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
9	Тайлант үеийн үр дүн			45,033,155.29	45,033,155.29
10					
11	2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			215,344,777.62	215,344,777.62
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			215,344,777.62	215,344,777.62
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
15	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
17	Тайлант үеийн үр дүн			55,959,845.77	55,959,845.77
18	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			271,304,623.39	271,304,623.39

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
18	Бараа, үйлчилгээний орлого	481,906,466.30	494,379,214.94
20	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	481,906,466.30	494,379,214.94
21	Үндсэн үйл ажиллагааны орлого	474,036,685.50	482,650,863.03
22	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	7,638,229.73	194,823.98
23	Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	-	8,704,897.00
25	Бусад орлого	231,551.07	2,828,630.93
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	481,906,466.30	494,379,214.94
28	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,061,357.01	458,260,186.28

29	Ажиллагчидтай холбогдсон зардал	280,086,947.82	308,027,283.49
30	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	276,186,020.82	277,571,501.00
31	Цалин	276,186,020.82	232,882,182.34
32	Нэмэгдэл	-	7,632,053.50
33	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,344,600.75
34	Үр дүнгийн урамшуулал	-	16,712,664.41
36	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	3,900,927.00	30,455,782.49
37	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,900,927.00	2,140,112.67
38	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	3,029,935.24
39	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	499,548.73
40	Тэтгэврийн даатгалын шимтгэл	-	19,755,219.02

41	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	5,030,966.83
42	Бараа үйлчилгээний урсгал зардал	159,974,409.19	150,232,902.79
43	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	41,098,574.00	51,387,490.00
47	Байрны түрээс	41,098,574.00	51,387,490.00
48	Хангамж, бараа материалын зардал	27,101,190.51	24,687,413.09
49	Бичиг хэрэг	5,312,795.00	3,779,910.00
50	Тээвэр, шатахуун	7,789,570.00	5,910,000.00
51	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,302,555.51	9,167,857.09
53	Дотоод албан томилолт	7,972,100.00	4,794,000.00
54	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,500.00	-
55	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	686,670.00	1,035,646.00
60	Эд хогшил, урсгал засварын зардал	11,569,446.00	9,393,221.00
61	Багаж техник хэрэгсэл	215,000.00	4,868,994.00
62	Тавилга	594,990.00	-
63	Урсгал засвар	957,350.00	4,524,227.00
64	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	9,802,106.00	-
65	Томилолт, зочны зардал	13,686,232.00	20,367,463.00
66	Гадаад албан томилолт	11,874,444.00	17,796,384.00
67	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,811,788.00	2,571,079.00
68	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,911,829.68	32,419,174.70
69	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,104,700.00	1,960,350.00
70	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,512,000.00	587,400.00
71	Даатгалын үйлчилгээ	2,231,000.00	1,791,825.30
72	Тээврийн хэрэгслийн татвар	1,100,000.00	220,500.00
73	Тээврийн хэрэгслийн оношлогоо	880,250.00	104,500.00

74	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,025,997.68	26,628,880.00
76	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	957,350.00	324,719.40
77	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлдэх	15,100,532.00	801,000.00
78	Бараа үйлчилгээний бусад зардал	27,607,137.00	11,978,141.00
80	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	17,788,270.00	4,024,694.00
81	Сургалт семинарын зардал	9,818,867.00	7,953,447.00
87	ТАТААС	16,138,032.00	3,895,000.00
88	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	16,138,032.00	3,895,000.00
89	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	16,138,032.00	3,895,000.00
92	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,969,738.00	5,225,230.00
93	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,452,280.00
95	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	1,452,280.00
96	Бусад урсгал шилжүүлэг	3,969,738.00	3,772,950.00
99	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,319,500.00	2,972,950.00
104	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,650,238.00	800,000.00
105	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	460,169,127.01	467,380,416.28
106	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	21,737,339.29	26,998,798.66
107	Хөрөнгийн орлого	-	-
124	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
132	Засгийн газрын бондын үндсэн төлбөр	-	-
133	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр	-	-
135	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	21,737,339.29	26,998,798.66
136	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	76,015,838.81	97,751,278.10
137	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,753,178.10	124,750,076.76

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	490,816,720.00	467,380,416.28	23,436,303.72	95.23
2	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	490,816,720.00	467,380,416.28	23,436,303.72	95.23
3	IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	490,816,720.00	467,380,416.28	23,436,303.72	95.23
4	Бараа, үйлчилгээний зардал	477,816,720.00	458,260,186.28	19,556,533.72	95.91
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	291,920,000.00	277,571,501.00	14,348,499.00	95.08

6	Үндсэн цалин	237,000,000.00	232,882,182.34	4,117,817.66	98.26
7	Нэмэгдэл цалин	9,600,000.00	7,632,053.50	1,967,946.50	79.50
8	Унаа, болон бусад нөхөн олговор	23,320,000.00	20,344,600.75	2,975,399.25	87.24
9	Үр дүнгийн урамшуулал	22,000,000.00	16,712,664.41	5,287,335.59	75.97
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,111,192.00	30,455,782.49	1,655,409.51	94.84
12	Тэтгэврийн даатгал	20,434,400.00	19,755,219.02	679,180.98	96.68
13	Тэтгэмжийн даатгал	2,409,192.00	2,140,112.67	269,079.33	88.83
14	ҮОМШӨ ний даатгал	3,147,600.00	3,029,935.24	117,664.76	96.26
15	Ажилгүйдлийн даатгал	510,000.00	499,548.73	10,451.27	97.95
16	Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	5,610,000.00	5,030,966.83	579,033.17	89.68
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,250,000.00	51,387,490.00	1,862,510.00	96.50
21	Байрны түрээс	53,250,000.00	51,387,490.00	1,862,510.00	96.50
22	Хангамж, бараа материалын зардал	19,961,080.00	19,893,413.09	67,666.91	99.66
23	Бичиг хэрэг	5,300,000.00	3,779,910.00	1,520,090.00	71.32

24	Тээвэр (шатахуун)	4,173,680.00	5,910,000.00	(1,736,320.00)	141.60
25	Шуудан холбоо	9,234,000.00	9,167,857.09	66,142.91	99.28
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,253,400.00	1,035,646.00	217,754.00	82.63
33	Эд хогшил худалдан авах	10,109,400.00	9,393,221.00	716,179.00	92.92
34	Багаж, техник, хэрэгсэл	5,753,400.00	4,868,994.00	884,406.00	84.63
37	Урсгал засвар	4,356,000.00	4,524,227.00	(168,227.00)	103.86
38	Томилолт, зочны зардал	24,694,310.00	25,161,463.00	(467,153.00)	101.89
39	Гадаад албан томилолт	17,694,310.00	17,796,384.00	(102,074.00)	100.58
40	Дотоод албан томилолт	4,000,000.00	4,794,000.00	(794,000.00)	119.85
41	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,000,000.00	2,571,079.00	428,921.00	85.70
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	32,730,238.00	32,419,174.70	311,063.30	99.05

42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00	1,960,350.00	39,650.00	98.02
42	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	587,400.00	1,412,600.00	29.37
43	Даатгалын үйлчилгээ	1,736,400.00	1,791,825.30	(55,425.30)	103.19
44	Тээврийн хэрэгслийн татвар	196,500.00	220,500.00	(24,000.00)	112.21
45	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	104,500.00	(38,500.00)	158.33
46	Мэдээллийн технологийн зардал	25,568,338.00	26,628,880.00	(1,060,542.00)	104.15
48	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	360,000.00	324,719.40	35,280.60	90.20
49	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	803,000.00	801,000.00	2,000.00	99.75
50	Бараа үйлчилгээний бусад зардал	13,040,500.00	11,978,141.00	1,062,359.00	91.85
52	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,480,000.00	4,024,694.00	455,306.00	89.84
53	Сургалт семинар зохион байгуулах зардал	8,560,500.00	7,953,447.00	607,053.00	92.91
57	TATAAC	10,000,000.00	7,667,950.00	2,332,050.00	76.68
58	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	6,000,000.00	3,895,000.00	2,105,000.00	64.92
60	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	1,452,280.00	1,547,720.00	48.41
61	Засгийн газар хоорондын шилжүүлэг	3,000,000.00	1,452,280.00	1,547,720.00	48.41
63	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,000,000.00	1,452,280.00	1,547,720.00	48.41
64	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	3,772,950.00	227,050.00	94.32
67	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	2,972,950.00	27,050.00	99.10
72	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,000,000.00	800,000.00	200,000.00	80.00
88	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	492,868,716.00	494,354,390.96	(1,485,674.96)	100.30
92	Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	-	8,704,897.00	(8,704,897.00)	-
93	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	490,828,716.00	482,650,863.03	8,177,852.97	98.33
94	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,040,000.00	170,000.00	1,870,000.00	8.33
95	Бусад орлого	-	2,828,630.93	(2,828,630.93)	-
105	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	97,751,278.10	(97,751,278.10)	-
106	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	124,750,076.76	(124,750,076.76)	-

107	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
108	АЖИЛЛАГСАД БҮГД	26.00	22.00	4.00	84.62
109	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
110	Гүйцэтгэх ажилтан	22.00	19.00	3.00	86.36
111	Үйлчлэх ажилтан	3.00	2.00	1.00	66.67
112	СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/	-	-	-	-
113	Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад	-	-	-	-